



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/690

Арвайхээр

Зардлын хуваарь батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/371 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас эрх шилжиж ирсэн 2018 онд Арвайхээр сумын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хуваарилсан зардлын 9.500.000 (есөн сая таван зуун мянга) төгрөгийг аж ахуйн нэгжийн халаалтын системийг байгаль орчинд эзлтэй, технологиор шийдэх ажил нэвтрүүлэх, 49.500.000 (Дөчин есөн сая таван зуун мянга) төгрөгийг төв захын орчин дахь жижиг халаалтын зуухнуудыг нэгтгэх дулааны шугам сүлжээний ажилд, 25.000.000 (хорин таван сая) төгрөгийг аж ахуйн нэгжүүдийг төвлөрсөн халаалтад холбох ажилд дэмжлэг үзүүлэх, 26.000.000 (хорин зургаан сая) төгрөгийг Арвайхээр цэцэрлэгжилт ОНӨААТҮГ-ын усан халаалтын зуухыг нэгтгэн шинэчлэх ажилд тус тус зарцуулсугай.

2. Агаарын бохирдлыг бууруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Т.Ариунболд)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101493